



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/650

Хэрлэн сум

Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг
урамшуулахад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.2, 11.1.7, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “Эрүүл мэнд, боловсролын байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр” батлах тухай 15 дугаар хуралдааны 5 дугаар тогтоол, 2023 оны 7 дугаар сарын 3-ны “Аймгийн 2023 оны төсвийн тодотгол батлах тухай” хорьдугаар хуралдааны 7 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.”Эрүүл мэнд, боловсролын байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн хүрээнд эрүүл мэндийн салбарт үр бүтээлтэй ажиллаж, тусламж үйлчилгээг иргэдэд чанартай үзүүлж буй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг урамшуулахад 18,400,000 (арван найман сая дөрвөн зуун мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын эрүүл мэнд, боловсролын салбарын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, арга хэмжээнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023
оны 12 дугаар сарын 19-ны
А/650 дугаар захирамжийн хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ ҮР БҮТЭЭЛТЭЙ АЖИЛЛАЖ БУЙ ЭМЧ, ЭМНЭЛГИЙН
АЖИЛЧДЫГ УРАМШУУЛАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Мэргэжлийн төрөл	Тоо	Урамшууллын хэмжээ
1	Нарийн мэргэжлийн эмч	1	500,000
2	Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмч	6	3,000,000
3	Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч	1	500,000
4	Захиргааны ажилтан, менежер	1	500,000
5	Уламжлалт анагаах ухааны эмч	1	500,000
6	Бодлогын мэргэжилтэн	1	500,000
7	Сувилагч	3	1,500,000
8	Лаборант	1	500,000
9	Эх баригч	1	500,000
10	Нийгмийн эрүүл мэндийн ажилтан	2	1,000,000
11	Зоонозын ажилтан	1	500,000
12	Эм зүйч, эм найруулагч	3	1,500,000
13	Дүн бүртгэгч бага эмч	2	1,000,000
14	Үйлчилгээний ажилтан	5	2,500,000
15	Жолооч / 5 хүн/	5	2,500,000
16	Өргөмжлөл		1,400,000
Нийт дүн		34	18,400,000